

Хэрхэн эхлэх вэ?


Хэрхэн эхлэх вэ?

Та Дээд Боловсролын Удирдлагын Мэдээллийн Системийг ашиглахдаа өөрийн төхөөрөмжнөөс веб хөтөч ашиглан **hemis.edu.mn** хаяг руу хандалт хийнэ.

Эхлэхээс өмнө системийн шаардлага хэсгээс хэрэглэгч систем ашиглахдаа ямар шаардлага хангасан байхыг харна уу.

Системд нэвтрэх

Веб хөтчийг ашиглан **hemis.edu.mn** хаягаар хандаж хэрэглэгчийн нэр, нууц үгийг ашиглан системд нэвтрэнэ.



The screenshot shows a web interface for logging into the Hemis system. At the top right, there is a blue header bar with a red number '3' and an orange button labeled 'Хадгалах' (Manage) with a close icon. Below this is a white box titled 'ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ' (Basic Information). A red number '2' is placed to the left of the form fields. The form contains the following fields:

- * Салбар, бүрэлдэхүүн: (сургууль ▾)
- * Хөтөлбөрийн төрөл: ЕБС - Бага боловсрол ▾
- * Суралцагчийн түвшин: 4-р анги ▾
- * Хичээлийн ангилал: Сонгон судлах хичээл ▾
- * Судлагдахуун: Англи хэл 🔍
- * Хичээлийн индекс: 04002 АНГ 04002
- * Хичээлийн нэр: Англи хэл 4 (АНГ 04002)

Системд нэвтрэх хэрэглэгчийн эрхийг БСШУСЯ-ны Дээд боловсролын мэдээллийн систем хариуцсан багаас авна.

Системтэй ажиллах

Системд нэвтрэсний дараа системийн нүүр хуудас дараах байдлаар харагдана.

Системтэй хэрхэн ажиллах талаар Хэрхэн ажиллах вэ? хэсгээс, системийн модулиудтай ажиллах талаар Системийн модуль хэсгээс дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.

Системээс гарах

Системээс гарах үйлдэл нь дараах хоёр янз байна:

- **Одоо ашиглаж байгаа веб хөтчөөс гарахдаа** Баруун дээд буланд байх хэрэглэгчийн нэр дээр дарж, гарч ирсэн цонхноос системээс гарах сонголтыг сонгоно.
- **Нийт нэвтэрсэн бүх веб хөтчөөс гарахдаа** Системийн тохиргооны хэсгээс бүх нэвтрэлтээс гарах сонголтыг сонгоно.

Хэрхэн ажиллах вэ?

Системтэй хэрхэн ажиллах вэ?

Дээд Боловсролын Мэдээллийн Системтэй ажиллахдаа дараах ойлголтуудыг мэдэх шаардлагатай.

Үүнд:

- Системтэй ажиллах дараалал
- Системийн нүүр хуудастай ажиллах
- Модулийн нүүр хуудастай ажиллах
- Үйлдэл хийх цонхтой ажиллах

Системтэй ажиллах дараалал

ДБУМС-д хэрэглэгчийн нэр, нууц үгийг ашиглан нэвтэрсний дараа эдгээр энгийн 3 алхмын дагуу модультай ажиллана.

- Системийн нүүр хуудас
- Модулийн нүүр хуудас
- Үйлдэл хийх цонх

- Системийн нүүр хуудас

Нүүр хуудас нь үйл ажиллагааны чиглэлийг бүлэглэсэн системийн модуль сонгох цэсүүдээс бүрдэнэ. Жишээ нь манай байгууллага, суралцагч, сургалтын хөтөлбөр, сургалтын агуулга, багш, сургалтын орчин,... гэх мэт.

- Модулийн нүүр хуудас

Ерөнхий цэс дээр дарахад тухайн үйл ажиллагааны чиглэлээр системд бүртгэсэн мэдээллийг жагсаалт хэлбэрээр харуулна. Мөн жагсаалтаас олон төрлийн нөхцлөөр хялбар, нарийвчилсан хайлт хийх боломжтой юм.

- Үйлдэл хийх цонх

Жагсаалтын цонхноос хийх үйлдлийг сонгосноор тухайн үйлдлийн дэлгэрэнгүй цонх руу шилжинэ. Үйлдэл нь шинэ бүртгэл хийх, мэдээллийн өөрчлөлт хийх,... зэрэг олон төрлийнх байх ба тухайн үйлдлээс хамаарч ажиллах цонх өөр өөр гарч ирнэ.

Системийн нүүр хуудастай ажиллах

Системийн нүүр хуудас дараах бүтэцтэй байна.

Тайлбар:

- 1. Системийн толгойн мэдээлэл
- 2. Системийн ажлын талбар
- 3. Системийн хөлний мэдээлэл

1. Системийн толгойн мэдээлэл

Системийн толгойн мэдээлэл нь системийн нэр, нэвтэрсэн хэрэглэгчийн байгууллагын нэр, нүүр хуудасруу үсрэх үйлдэл, нэвтэрсэн хэрэглэгчийн цэс болон онлайн тусламжийн системрүү шилжих үйлдэл зэргээс тогтоно.

Тайлбар:

- **1. Системийн нэр**

Дээд Боловсролын Удирдлагын Мэдээллийн Системийн нэр байна.

- **2. Байгууллагын нэр**

Системд нэвтэрсэн хэрэглэгчийн байгууллагын нэр байна.

- **3. Нүүр хуудасруу шилжих үйлдэл**

Ямар ч үйлдэл хийх цонхруу орсон байсан ч үйлдэл нь нүүр хуудасруу шилжүүлнэ.

- **4. Системд нэвтэрсэн хэрэглэгчийн нэр, хэрэглэгчийн цэс**

Системд нэвтэрсэн хэрэглэгчийн нэр байх ба энэ хэсэг дээр дарахад хэрэглэгчийн цэс гарч ирнэ. Хэрэглэгчийн цэснээс системээс гарах, хэрэглэгчийн тохиргоо,... зэрэг үйлдлүүд хийж болно.

- **5. Системийн онлайн тусламжруу шилжих үйлдэл**

Онлайн тусламжийн систем-рүү шилжих үйлдэл хийнэ.

2. Системийн ажлын талбар

Системийн ажлын талбар хэсэгт тухайн сонгогдсон цэсний ажиллах талбарыг харуулах ба хэрэв нүүр хуудас сонгогдсон бол модуль сонгох цэс гарч ирнэ.

Тайлбар:

- **1. Модуль сонгох цэс**

Манай байгууллага, Суралцагч, Багш,... зэрэг системийн модуль сонгох цэс байна.

3. Системийн хөлний мэдээлэл

Системийн модуль

Системийн модуль

Дээд Боловсролын Удирдлагын Мэдээллийн Систем нь дээд боловсролын сургалтын байгууллага, харъяа байгууллагад зориулсан, тэдгээрийн үйл ажиллагааг хялбаршуулсан модулиудаас бүрдэнэ.

Сургалтын байгууллага

Сургалтын байгууллагыг байгуулах, өөрчлөн байгуулах, мэдээлэл өөрчлөх, татан буулгах, ... зэрэг үйлдлийг удирдана. Дэлгэрэнгүй мэдээллийг сургалтын байгууллага хэсгээс харна уу.

Сургалтын агуулга

Хичээл, дадлага ажил, төгсөлтийн ажил, шалгалт зэрэг сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан

Сургалтын хөтөлбөр

**агуулгыг бүртгэж,
удирдана. Дэлгэрэнгүй
мэдээллийг сургалтын
агуулга хэсгээс харна уу.
Сургалтын хөтөлбөр,
төлөвлөгөө,
төлөвлөгөөний бүтцийг
зохион байгуулна.
Дэлгэрэнгүй мэдээллийг
сургалтын хөтөлбөр,
төлөвлөгөө хэсгээс харна
уу.**

Суралцагч

**Суралцагч шинээр
бүртгэх, суралцагчийн
профайль, суралцагчийн
хөдөлгөөн удирдах,
сургуулиас хасах зэрэг
суралцагчтай холбоотой
мэдээлэл, хөдөлгөөнийг
удирдана. Дэлгэрэнгүй
мэдээллийг суралцагч
хэсгээс харна уу.**

Багш

**Багш шинээр бүртгэх,
багшийн дэлгэрэнгүй
мэдээлэл бүртгэх,
багшийг бүртгэлээс хасах,**

Дүн үнэлгээ

**... зэрэг багштай
холбоотой үйл ажиллагааг
удирдана. Дэлгэрэнгүй
мэдээллийг багш хэсгээс
харна уу.**

**Суралцагчийн хичээлийн
дүн, шалгалтын дүн болон
дадлага ажлын дүнгийн
мэдээллийг удирдана.
Дэлгэрэнгүй мэдээллийг
дүн үнэлгээ хэсгээс харна
уу.**

**Боловсролын баримт
бичиг**

**Суралцагчийн төгсөлт,
баримт бичиг олголтын
мэдээллийг удирдана.
Дэлгэрэнгүй мэдээллийг
боловсролын баримт
бичиг хэсгээс харна уу.**

Сургалтын орчин

**Хичээлийн байр,
дадлагын байр, анги,
танхим, лаборатори, ...
зэрэг сургалтын орчны
мэдээлэл удирдана.
Дэлгэрэнгүй мэдээллийг
сургалтын орчин хэсгээс
харна уу.**

Тусгай зөвшөөрөл

Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн мэдээлэл, тусгай зөвшөөрлөөр олгосон мэргэжлийн чиглэл индексийг бүртгэх, өөрчлөх, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үйлдлийг удирдана. Дэлгэрэнгүй мэдээллийг тусгай зөвшөөрөл хэсгээс харна уу.

Ажилтан

Сургалтын байгууллагын хүний нөөцийн мэдээллийг удирдана. Дэлгэрэнгүй мэдээллийг Ажилтан хэсгээс харна уу.